



Blossom



ОЮУТНЫ ДОТУУР БАЙРНЫ "БИЕ ДААХ ӨРӨӨ"-Г ТОХИЖУУЛАХ ТӨСӨЛ

BLOSSOM БАГ



АГУУЛГА

- Төслийн үндэслэл
- Төслийн шийдэл
- Ялгарах онцлог
- Төслийн загвар,
хэрэгжих байдал
- Санхүүгийн тооцоолол
- Багийн танилцуулга





ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ



Улсын хэмжээнд нийт 69 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулдаг ба 71 дотуур байранд оюутан хүлээн авдаг. Нийт дотуур байрны:

50% нь 1979 оноос өмнө

31.8% нь 1980-1999 оны хооронд

18.2% нь 2000-2020 онд ашиглалтад орсон байна. Мөн 2020 оноос хойш шинээр дотуур байр ашиглалтад ороогүй бөгөөд дотуур байрны талаас илүү хувь нь барилгын чанар болоод оюутнуудын амьдрах орчин нөхцөлийг хангахад хүндрэлтэй болсон гэж харж байна.

Иймээс Улаанбаатар хот, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй их дээд сургууль, коллежийн дотуур байрны тохижуулалтыг засан сайжруулах, эрүүл, аюулгүй, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй амьдрах орчныг бүрдүүлэхэд энэ төслийн үндсэн зорилго оршино.



ЗОРИЛТОТ ХЭРЭГЛЭГЧ



МУИС-ийн III дотуур байрны оюутнууд

- Оюутны байрны 4 давхарт нийт 400 гаруй хүүхэд, нэг давхарт 110 орчим хүүхэд амьдардаг.
- 1,2,4 давхарт оюутанд зориулсан бие даах өрөө бий ч 1 давхарт байдаг нь засвар хийгдээгүй учир ажилладаггүй. 400 гаруй оюутанд 2 давхарын хичээл хийх өрөө хангалттай хүрч чадахгүй байгаагаас гадна дотуур байрны стандартыг огт хангахгүй байна.

Стандарт хэмжил зүйн газрын даргын 2020.12.31-ний өдрийн С/62 тушаалын 4-т зааснаар дотуур байр нь дараах шаардлагыг хангасан байна.

4.7 Хичээл давтах өрөө

4.7.1 Нийт суралцагчдын 20% нэг дор үйлчлэх боломж бүхий ширээ сандал, ширээ, самбартай, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.

4.7.2 Хичээл давтах өрөөг мэргэжлийн сурах бичиг, уран зохиолын ном, гарын авлага, цахим сургалтын С тоглуулагчаар хангана.

Эх сурвалж: <https://estandard.gov.mn/standard/readers>



ТӨСЛИЙН ШИЙДЭЛ



Оюутны дотуур байрны бие даах өрөөг стандартын ширээ, сандал, мэргэжлийн сурах бичиг, уран зохиолын ном, гарын авлага, цахим сургалтын тоног төхөөрөмжүүд болох компьютер, ухаалаг самбар зэргээр хангах.

Тэр дундаа МУИС-ийн III дотуур байрны 1 давхарын бие даах өрөөг бүрэн тохижуулах. Үүнд:

- Стандартын ширээ, сандал
- Ухаалаг самбар
- Номын тавиур болон төрөл бүрийн ном, сурах бичиг
- Компьютер түүний дагалдах хэрэгсэл
- Гэрэлтүүлэг
- Буйдан багтана.



ЯЛГАРАХ ОНЦЛОГ



Энэ төсөл нь богино хугацаанд хэрэгжих боломжтой бөгөөд иргэн, аж ахуй нэгж, төр, төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэхэд боломжтой.

Тухайн өрөөг олон улсын стандартад нийцсэн тавилга, тоног төхөөрөмжөөр тохижуулахаас гадна оюутнуудын сурах, орлого олох зэрэг нийгмийн хэрэгцээг хангаж чадах орчин нөхцөлийг бүрдүүлэх учир бусад дотуур байрны бие даах өрөө болон шинээр баригдах дотуур байранд шууд хэрэгжүүлж болно.



ТӨСЛИЙН ЗАГВАР, ХЭРЭГЖИХ БАЙДАЛ





Дотуур байрны одоогийн байдал

Төслийн ерөнхий зураглал

САНХҮҮГИЙН ТООЦООЛОЛ

Нийт шаардагдах санхүүжилт

- Стандартын ширээ- 12 ширхэг- 2,256,000₮
- Стандартын сандал-24 ширхэг-6,528,000₮
- - Ухаалаг самбар-1 ширхэг-2,500,000₮
- - Номын тавиур - 1 ширхэг-450,000₮
- -Төрөл бүрийн ном- 100 ном-2,500,000₮
- - Компьютер дагалдах хэрэгсэл-3 ширхэг- 6,900,000₮
- - Гэрэлтүүлэг- 12 ширхэг-1,500,000₮
- -Номын тавиурын дэргэдэх буйдан-1 ширхэг-400,000₮
- -Нийт- 23,000,000₮





БАГИЙН ТАНИЛЦУУЛГА



Б. Аминцэцэг

Ахлагч



Б. Номин-Эрдэнэ

Тайлан тооцоо хариуцагч




Н. Ундрага

Мэдээлэл бэлтгэгч



Д. Энхмаа

Зураг төсөл



Анхаарал хандуулсанд баярлалаа